



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баяндалай сумын Гурванмөнх ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨМА-2023/24/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn

Өмнөговь аймаг
2023 он

Хаан консалтинг аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал:
Ч.Баярсайхан
Утас: 89000060 Цахим хаяг: bayaraach85@gmail.com

Аудитын менежер: Г.Ганцэцэг
Утас: 88883775 Цахим хаяг: jni.gantsetseg@gmail.com

Ахлах аудитор: Ш.Мөнхцэцэг
Утас: 99799039 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.15 № 234

танай _____-ны № _____-т

БАЯНДАЛАЙ СУМЫН
ГУРВАНМӨНХ ОНӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Т.ЭРДЭНЭБААТАР
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баяндалай сумын Гурванмөнх ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Баяндалай сумын Гурванмөнх ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд тусгагдсан татварын өрийг 25.0 сая төгрөгөөр, татварын авлагыг 12.5 сая төгрөгөөр буруу бүртгэсэн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд НӨАТ-ын тухай хуулийн 16 дугаар зүйл "Албан татвар ногдуулах, тайлагнах" хуульд нийцээгүй, санхүүгийн тайлангийн "эрх ба үүрэг", "тохиолдсон байх", "толилуулга ба тодруулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,165.5 сая төгрөгийн сумын төвийн болон шугам өргөтгөх шинээр барих ажлыг барилга байгууламж дансанд орлогодож авсан байна.

Аудитын гол асуудал

Баяндалай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны тогтоолоор 71.9 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил акталж данснаас хассан байна.

016020323

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	126,174.5	99,633.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,390,803.5	2,522,637.7
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,516,978.0	2,622,271.4
	Өр төлбөрийн нийт дүн	981,373.6	2,146,024.8
	Эзэмшигчдийн өмчийн дүн	535,604.4	476,246.6
	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	1,516,978.0	2,622,271.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Борлуулалтын орлогын дүн	322,105.7	339,728.8
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөгийн дүн	276,674.7	335,494.6
	Нийт ашиг алдагдал	45,430.9	4,234.2
	Бусад орлого	43,491.9	43,491.9
	Ерөнхий ба удирдлагын зардал	43,851.2	78,780.9
	Бусад зардал	-	-
	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	40,564.5	(59,357.8)
	Орлогын татварын зардал	-	-
	Татварын дараах ашиг (алдагдал)	40,564.5	(59,357.8)
	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	40,564.5	(59,357.8)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	431,826.9	535,604.4
	Тайлант оны үр дүн	40,564.5	(59,357.8)
	Эцсийн үлдэгдэл	472,391.4	476,246.6
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	352,063.0	375,665.6
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	325,700.1	331,950.8
	Үйл ажиллагааны ЦМГ	26,362.9	43,714.8
	Мөнгөн зарлагын дүн	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(58,023.7)
	Мөнгөн зарлагын дүн	-	58,023.7
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	26,362.9	(14,308.8)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,878.8	28,241.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,241.7	13,932.9
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт орлого	381,569.4	102,325.9
	Нийт зардал	378,684.8	38,998.4
	Нийт ашиг, алдагдал	2,884.6	63,327.6

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 12.5 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 12.5 сая төгрөгийн алдааг залруулах зөвлөмж өглөө.

Үүнд: Шатах тослох материалын худалдан авалтыг журналд бүртгэхдээ НӨАТ-ын авлага дансаар дамжуулаагүй, өр төлбөрийн дансаар дамжуулан бүртгэсэн нь НӨАТ-ын тооцоо дансны зөрүүг үүсгэсэн байна. Санхүүгийн тайланд НӨАТ-ын авлага, өглөгийн дансны үлдэгдлийг баталгаажуулах.

Аудитаар нийт 34.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 4.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 29.0 сая төгрөгийн албан шаардлага, 0.7 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Төлбөрийн акт

Гурван мөнх ОНӨААН-н дарга удаан жил ажилласан нэмэгдэл 1.3 сая, ур чадварын нэмэгдэл 2.9 сая, үр дүнгийн нэмэгдэл 398.2 сая төгрөгөөр тус тус илүү тооцож олгосон зөрчилд төлбөрийн акт хүргүүлсэн.

Албан шаардлага

1. Санхүүгийн тайлангийн үлдэгдлийн тулган баталгаажуулалтыг анхан шатны баримтаас хөөн шалгаж үзэхэд нийт 3.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн ба Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг Хаан банкны үлдэгдэл баталгаажуулалт бүрэн хийгдэн, Авлагын 3.3 сая төгрөгийн авлагын баталгаажуулалтыг хийгээгүй, НӨАТ-ын өр төлбөр болон ААНӨАТ нийт 0.2 сая төгрөгийг Татварын байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.
2. Санхүүгийн тайлангийн Татварын өр төлбөр дансны үлдэгдэл 196.8 сая төгрөгөөр тайлагнаж, Маягт ТТ-03а Нэмэгдсэн өртгийн албан татварын суутган төлөгчийн тайлангийн жилийн эцсийн тооцоогоор төлбөл зохих үлдэгдэл 4.2 сая төгрөг, ТТ -02 маягт Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн нийт төлбөл зохих татварын үлдэгдэл 165.7 сая төгрөг, ТТ -12 Суутган төлөгчийн хувь хүнд олгосон орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлангийн албан татвар суутгаагүй олгосон татвар ногдох орлогыг 0 төгрөг, суутгасан татварын орлогыг 0 төгрөгөөр тайлагнасан, ТТ-11 Цалин хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлангийн суутгасан нийт албан татвар 9.1 сая төгрөгөөр тайлагнасан байна. Санхүүгийн тайлангийн Татварын өр төлбөр дансны үлдэгдэл нийт 196.8 сая төгрөг байгаа нь байх ёстой үлдэгдлээс 24.9 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.
3. Аудитаар анхан шатны баримт, журнал, санхүүгийн тайлангаас тулган шалгахад НИК ХХК-тай байгуулсан худалдан авалтын гэрээний хөнгөлөлтийн 3 хувь болох 0.6 сая төгрөгийг бусад орлого дансаар бүртгээгүй зэрэг зөрчлүүдэд албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Тайлант оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/678 дугаар Өмнөговь аймгийн Засаг даргын захирамжаар 7.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосныг бусад зардлын дансанд 6.7 сая төгрөгөөр бүртгэж, 0.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТШЗ												
ОНӨААТҮГ	1	12.5			1	12.5	1	12.5				
Дүн	1	12.5			1	12.5	1	12.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТШЗ												
ОНӨААТҮГ	5	34.4	1	4.6	2	28.4	2	1.3				
Дүн	5	34.4	1	4.6	2	28.4	2	1.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТШЗ								
ОНӨААТҮГ	1	28.9			1	28.9		
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТШЗ								
ОНӨААТҮГ								
Дүн								
Нийт дүн	1	28.9			1	28.9		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ОНӨААТҮГ						1		
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ						1		